# УЛААНБААТАР
# ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

1987 оны 4 сарын 28 өдөр    Дугаар 112    Улаанбаатар хот

Иргэний хамгаалалтын сургалтын талбай байгуулах тухай

Улсын иргэний хамгаалалтын газартай тохиролцсоныг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I.Иргэний хамгаалалтын сургалтын талбайг зохих зураг, төсвийн дагуу байгуулахыг хотын иргэний хамгаалалтын штаб /Р.Лувсансамбуу/-т зөвшөөрсүгэй.

2.Иргэний хамгаалалтын сургалтын талбай байгуулахад зориулан Октябрийн районы ОСГ-ын I хорооны дэвсгэрт Тахилтын амыг хавсралт схемийн дагуу I7 га. газар олгохыг Архитектур төлөвлөлтийн газар /Т.Мядамбаа/-т зөвшөөрсүгэй.

3.Сургалтын талбайд хийх ажлын хуваарийг хавсралтаар батласугай.

4.Сургалтын талбай барихад шаардагдах барилгын материал, авах, тээврийн зардалд хотын төсвийн нийт орлогын төлөвлөгөө давуулсны шагналын хөрөнгөнөөс 50,0 мянган төгрөг гаргахыг Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс /Л.Эрдэмбат/-т үүрэг болгосугай.

5.Найрамдлын районы иргэний хамгаалалтын сургуулийн талбайн сахиулын орон тоог Октябрийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаанд шилжүүлэхийг Хотын санхүүгийн хэлтэс /Л.Эрдэмбат/-т зөвшөөрсүгэй.

6.Хотын иргэний хамгаалалтын сургалтын талбайд шаардлагатай цахилгаан, телефоны шугамтай болгохыг Улаанбаатар хотын эрчим хүчээр хангах, гэрэл өнгөлөн далдлах, холбоо зарлан мэдээллийн албадад /М.Чимэд, Б.Ванзрагч/ үүрэг болгосугай.

7.Иргэний хамгаалалтын сургалтын талбай байгуулахад шаардагдах тээврээр хангахыг Хотын тээврийг удирдах газар /Л.Түдэв/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА С.ЭНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ

Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны
1987 оны сарын ны өдрийн
тоот тогтоолын хавсралт

# 1987 ОНД СУРГУУЛИЙН ТАЛБАЙД ХИЙХ АЖЛЫН ХУВААРЬ

| №: | Хийх ажлын нэр | Хариуцах район, байгууллага | хугацаа |
|---|---|---|---|
| I. | Сааддтай зурвас | Хот, Октябрийн районы штаб | YI/I-ний дотор |
| 2. | Цахилгааны шугам тавих | Ажилчин район, ЭХЖТОД алба | YII/I |
| | -Сааддтай зурвасны I2.13 дугаар элемент | Ажилчин район | YI/I |
| | -Ачааны машины кузов I ш | -"- | Y/20 |
| 3. | Жагсаалын талбайг цонхжолж уртасгах | Сүхбаатарын район | Y/25 |
| | -УАЗ машины кабин I ш-г олж суулгах, будах | -"- | Y/I5 |
| 4. | Цагаан байшинг шалдах | Найрамдлын районы штаб | Y/20 |
| | -Ачааны машины кузов I ш-г олж суулгах, будах | -"- | -"- |
| 5. | Цэвэр усны ёмкость I ш, посшик I ш, таг, кранттай, хөл хийж будах суулгах. | Хотыг усаар хангах, усн цэг хамгаалах алба | Y/I5 |
| 6. | Телефоны шугам тавих | Хотын ХЭМ-ийн алба | YI/I |
| 7. | Ачааны машины кузов I ш-г олж хөл хийж будах | Хотын тээврийн алба | Y/I5 |
| 8. | Түргэн тусламжийн машины кабин I ш-г олж хөл хийж суулгах, будах | -"- | -"- |
| 9. | Модон байруудыг тус бүр I-ийг ширээр нэмж барих. | Хотын хүнсээр хангах, хувцас, эд хэрэглэлээр хангах, нийтийн хоолоор хангах, тээвэр, хоргодох цацдлах байрны албад | YIII/I |

УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ШТАБ